

Монгол Улсын Үндэсний Аудитын газар

ҮАГ

Үндэсний Аудитын газрын 2004 оны бүтээгдэхүүн,
ажил, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу
хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан

2004 оны 6 дугаар сар

**ХӨТӨЛБӨРИЙН
ХЭРЭГЖИЛТИЙГ
ЭРЧИМЖҮҮЛЭХ
ШААРДЛАГАТАЙ БАЙНА**

**”Бөөний худалдааний сүлжээ”
хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр
дүн**

Улаанбаатар хот

Агуулга

Ерөнхий зүйл	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй	1-2
	Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд	2-3
	Аудитын стандартын талаархи мэдэгдэл	3-3
Аудитын дүн	Засгийн газрын 2001 оны 219 дүгээр тогтоолоор батлагдсан “Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний биелэлт, үр дүн	4-6
	“Бөөний худалдааны сүлжээ” шинэчилсэн хөтөлбөрийг хэрэгжүүлэх аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулах тендерийн зохион байгуулалт	6-10
	“Бөөний худалдааны сүлжээ” хөтөлбөрийг хэрэгжүүлэх зээлийн гэрээний биелэлт	10-15
	Төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлөөр олгосон хөрөнгийн ашиглалт, зарцуулалт, эргэн төлөлт	15-16
	“Бөөний худалдааны сүлжээ” төслийн нэгжийн 2002, 2003 оны төсвийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалт	16-17
Аудитын дүгнэлт	Аудитын дүгнэлт	18-19
Холбогдох байгууллагын санал	Санхүү, эдийн засгийн яамны санал	20-20
	Үйлдвэр, худалдааны яамны санал	21-22
	Үндэсний аудитын газрын тайлбар	23-24
Аудитын зөвлөмж	Аудитын зөвлөмж	25-26

Агуулга

Товчилсон үгс:

ҮАГ-Үндэсний аудитын газар
ЗГ-Засгийн газар
ҮХЯ-Үйлдвэр, худалдааны яам
СЭЗЯ-Санхүү, эдийн засгийн яам
БХС-Бөөний худалдаа сүлжээ
БХ-Бөөний худалдаа
ХБХА-Худалдааны бодлого, хамтын ажиллагаа
ГХОГХ-Гадаадын хөрөнгө оруулалт, гадаад худалдаа

Ерөнхий зүйл

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Үндэсний аудитын газрын 2004 оны бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд “Бөөний худалдааны сүлжээ” /БХС/ хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийв.

Энэхүү аудитын зорилт нь:

- Засгийн газрын 2001 оны 219 дүгээр тогтоолоор батлагдсан “Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний биелэлт, үр дүн
- Төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлөөр олгосон хөрөнгийн ашиглалт, зарцуулалт, эргэн төлөлт
- “Бөөний худалдааны сүлжээ” шинэчилсэн хөтөлбөрийг хэрэгжүүлэх аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулсан тендерийн зохион байгуулалт
- “Бөөний худалдааны сүлжээ” төслийн нэгжийн 2002, 2003 оны төсвийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалтын байдалд аудит хийж дүгнэлт өгөх явдал байв.

Аудитад Санхүү, эдийн засгийн яам, Үйлдвэр, худалдааны яам, “БХС” төслийн нэгж болон экспортыг дэмжих төв, Хэнтий, Баянхонгор, Орхон, Архангай аймгуудад БХС хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа аж ахуйн нэгжүүд хамрагдав.

Аудитыг холбогдох хүмүүстэй ярилцлага хийх, санал солилцох, тайлбар нотолгоо авах, орлого, зарлагыг анхан шатны баримтаар түүвэрлэн шалгах, тулган баталгаажуулах, төсөвт зардлын гүйцэтгэлийг харьцуулах, нөхцөл байдлын шинжилгээ хийх, дээрх аймгуудад асуулга хуудас ашиглан санал асуулга, судалгаа явуулах зэрэг гүйцэтгэлийн аудитын арга зүй, үндсэн горимуудыг ашигласан болно.

“Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын 2000 оны 33 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газрын 2000 оны 179 дүгээр тогтоолоор Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлан гаргажээ. Засгийн газрын хөтөлбөрт зааснаар 2000-2004 онд “БХС” хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр тусгасан байна.

Ерөнхий зүйл

Дээрх тогтоолыг үндэслэн Монгол Улсын Засгийн газрын 2001 оны 219 дүгээр тогтоолоор “Бөөний худалдааны сүлжээ” шинэчилсэн хөтөлбөр, хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө болон уг ажлыг зохион байгуулах, зохицуулах, хяналт тавих үүрэг бүхий Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг батлажээ.

“Бөөний худалдааны сүлжээ” шинэчилсэн хөтөлбөрийн зорилго нь “Хүн амыг чанар сайтай хүнс, өргөн хэрэглээний бараагаар, үйлдвэрлэлийг түүхий эдээр тасралтгүй хангах, бараа, түүхий эдийн бэлтгэл, нийлүүлэлтийн зохистой тогтолцоо бий болгох, бараа, түүхий эдийн хадгалалт, тээвэрлэлтийг оновчтой болгох замаар зах зээлийн бодит үнийн түвшинг бүрдүүлж хот, хөдөөгийн хоорондох үнийн зөрүүг багасгахад оршино” гэж заажээ.

Гүйцэтгэлийн аудитыг Үндэсний аудитын газрын хоёрдугаар хэлтсийн дарга О.Мэндбаяр удирдаж, тус хэлтсийн болон Орхон, Хэнтий, Баянхонгор, Архангай аймгийн аудитор, шинжээч нар 2004 оны 5 дугаар сарын 14-нөөс 6 дугаар сарын 30-ний өдрүүдэд гүйцэтгэв.

Аудитад
ашигласан
шалгуур
үзүүлэлтүүд

Дараахь хууль тогтоомжийн заалтыг энэхүү аудитад шалгуур болгон ашиглав. Үүнд:

- Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хууль
 - Монгол Улсын Нэгдсэн төсвийн тухай хууль
 - Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
 - Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журмын тухай хууль
 - Монгол Улсын Засгийн газрын 2000 оны 179 дүгээр тогтоол
 - Монгол Улсын Засгийн газрын 2001 оны 219 дүгээр тогтоолоор баталсан “Бөөний худалдааны сүлжээ” шинэчилсэн хөтөлбөр
 - Монгол Улсын Засгийн газрын 2003 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн хуралдааны 24 дүгээр тэмдэглэл
 - Үйлдвэр, худалдааны сайдын 2000 оны А/52 дугаар тушаал
 - Үйлдвэр, худалдааны сайдын 2002 оны 67 дугаар
-

Ерөнхий зүйл

тушаал

- Санхүү, эдийн засгийн сайд, Үйлдвэр, худалдааны сайдын 2002 оны 33/10 дугаар тушаал
- Санхүү, эдийн засгийн сайд, Үйлдвэр, худалдааны сайдын 2003 оны 157/93 дугаар тушаал
- Холбогдох бусад хууль, тогтоомж

Аудитын
стандартын
талаархи
мэдэгдэл

Энэхүү гүйцэтгэлийн аудитыг хийхэд Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын журмыг баримталсан бөгөөд Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан гүйцэтгэлийн аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийг мөрдөж ажиллав.

Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын журамд заасны дагуу аудитын дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох бусад мэдээллийг ажлын баримт материалд хавсаргав.

Аудитын дүн

БХС
хөтөлбөрийг
хэрэгжүүлэх
төлөвлөгөө-
ний биелэлт,
үр дүн

Монгол Улсын Засгийн газрын 2001 оны 219 дүгээр тогтоолоор “Бөөний худалдааны сүлжээ” шинэчилсэн хөтөлбөр болон хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг баталсан байна.

“Бөөний худалдааны сүлжээ” хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тусгагдсан 9 арга хэмжээний хэрэгжилтийг шалгахад дараахь байдалтай байна.

1.Худалдааны тухай хууль, түүнийг дагалдах хуулиудын төслийг санаачилж, УИХ-д өргөн барих ажлыг 2002 онд багтаан хийх байсан боловч гадаад худалдааны үзэл баримтлалыг гаргасны үндсэн дээр уг хуулийг боловсруулахаар болж хойшлогдсон байна.

2.БХС-г бүрдүүлэхэд шаардагдах стандарт, техникийн нөхцөлүүдийг боловсруулж батлах ажлыг 2001-2002 онд хийхээр төлөвлөжээ. Энэ арга хэмжээний хүрээнд мал аж ахуйн гаралтай түүхий эдийн болон өргөн хэрэглээний хүнсний бүтээгдэхүүний 58 стандартыг боловсруулан батлуулжээ. Харин хүнс болон хүнсний бус түүхий эдийн агуулахын стандартууд батлагдаж гараагүй байна.

3.Бөөний худалдааны мэдээллийн сангийн төсөл боловсруулж, зохион байгуулах ажлыг 2001 онд багтаан хийхээр төлөвлөсөн боловч тухайн ондоо энэ ажил хийгдээгүй байна. Харин 2002 оны 12 дугаар сарын 26-нд “Нэтэкс” ХХК-тай бөөний худалдаа эрхэлдэг аж ахуйн нэгжүүдийн бараа бүтээгдэхүүний үнэ, нэр төрлийг сурталчлах зорилгоор ТБ-02 дугаар гэрээ байгуулан ажиллажээ.

4.Бөөний худалдааны мэдээллийн сүлжээг дэмжих төвийн ажлыг эрхлэх аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулж, ажлыг нь 2002 онд эхлүүлэх төлөвлөгөөт арга хэмжээ бүрэн хэрэгжээгүй байна. Мэдээллийн сан байгуулах төсөл боловсруулах ажлыг төмөр замын дагуу байрлах шилэн кабелиар холбогдсон “Нэтэкс” ХХК-тай хамтран хийж, бөөний худалдаа эрхэлдэг аж ахуйн нэгжүүдийн бараа бүтээгдэхүүний үнэ, нэр төрлийг сурталчлах зорилгоор, БХС хөтөлбөрийн вэб сайтыг бий болгож дээрх мэдээллийн компанийн вэб сайтын бүтцэд оруулсан байна. Гэвч энэ веб сайтыг цаашид ашиглах боломжгүй болж 2003 онд БХС төслийн нэгж 3.2 сая төгрөгөөр мэдээллийн вэб сайтыг нээн ажиллуулжээ.

Аудитын дүн

5. Улаанбаатар хотод бараа, түүхий эдийн төрөлжсөн болон холимог агуулах, бөөний худалдааны төв байгуулах асуудлыг судалж, байршлыг тогтоон дээрх үйл ажиллагааг эрхлэх аж ахуйн нэгжүүдийг шалгаруулах, шинээр байгуулахад дэмжлэг үзүүлэх арга хэмжээг 2001-2002 онд багтаан хэрэгжүүлэхээр төлөвлөжээ.

Гэвч энэ арга хэмжээний хүрээнд БХС төслийн нэгж Нийслэлийн захирагчийн БХС дэд хөтөлбөрийн төсөлтэй хамтарч түүхий эдийн захыг Улаанбаатар хотоос Налайх, Эмээлт тосгонд шилжүүлснээс өөр ажил хийгдээгүй, түүхий эдийн захыг нэгдсэн зохион байгуулалтанд оруулж чадаагүй, түүхий эдийн төрөлжсөн бирж байгуулагдаагүй байна.

6. Бүсийн хөгжлийн үзэл баримтлалын хүрээнд аймгуудад бирж, бөөний худалдааны төв зохион байгуулах ажил 2001 онд хийгдэх ёстой байсан боловч хугацаа хоцорч 2002 онд Баянхонгор, Хэнтий, Орхон аймгуудад, 2003 онд Завхан, Архангай, Өмнөговь, Дорнод аймгуудад бөөний худалдааны төвийг зохион байгуулжээ. Дээрх аймгуудад улсын төсвөөс эргэж төлөгдөх нөхцөлтэй хүүгүй зээл 2002 онд 650.0 сая төгрөг, 2003 онд 850.0 сая төгрөг, нийт 1500.0 сая төгрөг олгосон нь анх хөтөлбөрт тусгагдсан дүнгээс 320.0 сая төгрөгөөр дутуу байна.

Аудитад хамрагдсан 4 аймагт төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн байгууллагууд нь түүхий эдийн бирж зохион байгуулах ажил хийгээгүй байна.

7. Бирж, бөөний худалдааны төв, агуулахад байгаа үлдэгдэл бараа, түүхий эд, ирээдүйд бэлдэх түүхий эд, барааны дүнгээр вексель, өрийн бичиг гаргах, түүнийг мөнгөжүүлэх талаар чиглэл гаргаж банк болон банк бус санхүүгийн байгууллагуудтай тохиролцох, Монгол банкнаас хийх вексель өрийн бичгийн туршилтанд зарим бараа, түүхий эд бэлтгэн нийлүүлэгчдийг хамруулах зэрэг төлөвлөгдсөн ажлууд хийгдээгүй байна.

8. Бөөний худалдааны мэдээллийн сүлжээ байгуулах төслийг хандивлагч орнуудын зээлийн төсөлд хамруулах арга хэмжээг 2001 оны 6 дугаар сард багтаан авч 2000,0 сая төгрөгийн эх үүсвэрийг хандивлагч орнуудын зээл, тусламжаар санхүүжүүлэхээр заажээ.

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээнд Европын холбоотой хамтран ажиллахаар тохиролцож зүүн 3 аймагт БХС байгуулах төслийг хэрэгжүүлэх зорилгоор 2003 онд 1.7 сая евро

Аудитын дүн

гаргуулахаар эцэслэн шийдвэрлэж төслийн ажлыг гүйцэтгэх компанийг шалгаруулах тендер зарласан байна. Энэ ажил төлөвлөсөн хугацаанаасаа нилээд хоцорч байна.

9.БХС хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах чиглэл, төлөвлөгөөг тохиролцон, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах зорилтын хүрээнд үйл ажиллагаа ойролцоо төслийн болон хоршоодын төв байгууллагуудтай хамтарч сургалт, семинар зохион байгуулж байгаа боловч хамтран ажиллах чиглэл, цаашид хэрэгжүүлэх ажлууд төлөвлөгдөөгүй байна.

БХС хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтээс үзэхэд төлөвлөгөөт ажлууд хугацаа хоцорч эхэлснээс гадна зарим нь хойшлогдсон, төлөвлөгдсөн нилээд ажил хийгдээгүй байна.

БХС
шинэчилсэн
хөтөлбөрийг
хэрэгжүүлэх
аж ахуйн
нэгжийг
сонгон
шалгаруулсан
байдал

Монгол Улсын Засгийн газрын 219 дүгээр тогтоолоор “БХС” шинэчилсэн хөтөлбөрийг эхний шатанд 2001 онд Баянхонгор, Хэнтий, Орхон аймгуудад, хоёрдугаар шатанд 2002 онд Ховд, Дархан-Уул, Завхан, Өвөрхангай, Дорнод аймгуудад тус тус хэрэгжүүлэхээр заажээ.

Мөн 2002 онд БХС хөтөлбөрийг хэрэгжүүлэх Ховд, Дархан-Уул, Өвөрхангай аймгуудыг өөрчлөн 2003 онд Архангай, Өмнөговь аймагт хэрэгжүүлэхээр сонгосон байна. Энэ талаар Засгийн газрын 2003 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн хурлаар хэлэлцсэн боловч тогтоол, шийдвэр гаргаагүй бөгөөд зөвхөн хуралдааны 24 дүгээр тэмдэглэлд дээрх 2 аймгийг шинээр оруулж улсын төсвөөс санхүүжүүлэхийг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаанд зөвшөөрчээ.

1.Санхүү, эдийн засгийн сайд, Үйлдвэр худалдааны сайдын 2002 оны 33/10 дугаар тушаалаар Баянхонгор, Хэнтий, Орхон аймгуудад түүхий эдийн бирж, бөөний худалдааны төвийг зохион байгуулах аж ахуйн нэгжийг хуулийн дагуу шалгаруулж явуулахыг СЭЗЯ, ҮХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга нарт даалгажээ.

СЭЗЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2002 оны 3 дугаар сарын 29-ний өдрийн 77 дугаар тушаалаар “Бөөний худалдааны сүлжээ” хөтөлбөрийг Баянхонгор, Хэнтий, Орхон аймгуудад хэрэгжүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах яам дундын тендерийн хороог 7 хүний , үнэлгээний хэсгийг 5 хүний

Аудитын дүн

бүрэлдэхүүнтэй баталжээ.

Яам дундын тендерийн хороо нээлттэй тендерийг 2002 оны 4 дүгээр сарын 4-нд зарлаж тендерийн бичиг баримтыг нийт 12 компани худалдан авч, 6 оролцогч 10 багцад саналаа ирүүлжээ.

№	Төсөл хэрэгжүүлэх аймаг	Санал ирүүлсэн аж ахуйн нэгж			
1	Баянхонгор	“Тэнгэр” ХХК	“Хүнс трейд” ТӨҮГ	“Мандал Алтай” ХХК	“Таван богд трейд” ХХК
2	Хэнтий	“Тэнгэр” ХХК	“Хүнс трейд” ТӨҮГ	“Буудайн цацал” ХК	
3	Орхон	“Тэнгэр” ХХК	“Хүнс трейд” ТӨҮГ	“ТБД андууд” ХХК	

Үнэлгээний аргачлалыг нарийн тооцож боловсруулаагүйгээс үзүүлэлтүүдийг үнэлсэн үнэлгээний нийт дүнг гаргах боломжгүй, аль үзүүлэлтийг гол болгосон нь тодорхойгүй байна. Жишээ нь: Баянхонгор аймагт хөтөлбөр хэрэгжүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан тендерийн үнэлгээний хэсэг “Тэнгэр” ХХК-ийг төлбөрийн чадвар болон тогтвортой байдлын буюу санхүүгийн чадавхийг үнэлдэг альтманы индексийн үнэлгээгээр тендэрт оролцогчдоос хамгийн сайн үнэлгээ авсан, зээлийг эргэн төлөх санхүүгийн чадвар, нөөц, худалдаа технологийн үзүүлэлтүүд нь сайн байна” гэсэн үнэлэлт өгч “Тэнгэр” ХХК-ийг шалгаруулсан байна.

Гэтэл “Хүнс трейд” ТӨҮГ төлбөрийн чадвар, тогтвортой байдлын үзүүлэлтээрээ нөгөө 2 компаниасаа хэд дахин сайн, борлуулалтын орлого, эргэлтийн хөрөнгө, үл хөдлөх хөрөнгийн дүнгээрээ 3-5 дахин илүү байжээ. Худалдаа технологийн үзүүлэлт гэдэгт нийт 12 үзүүлэлт багтаж байгаа бөгөөд ямар системээр дүгнэсэн нь тодорхойгүй байгаа ба 3 компанийн энэ үзүүлэлт ойролцоо байхад “Тэнгэр” ХХК-ийг шалгаруулсан нь ойлгомжгүй байна.

Хэнтий аймагт хөтөлбөр хэрэгжүүлэхээр санал ирүүлсэн “Буудайн цацал” ХК нь үнэлгээний хэсгийн дүгнэлтээр төсвийн зээлийн 200 сая төгрөгийн банкны батлан даалт ирүүлээгүй, мөн худалдаа технологийн болон санхүүгийн чадвараараа бусад оролцогчдоос доогуур байна” хэмээн үнэлжээ.

“Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журмын тухай” хуулийн 4.1.20-д зааснаар “гүйцэтгэлийн баталгаа” гэж тухайн

Аудитын дүн

тендер шалгаруулалтанд шалгарсан тендерт оролцогчийн гэрээний үүргийн биелэлтийг хангах зорилго бүхий, тендерийн бичиг баримтанд заасан мөнгөн дүнтэй банкны батлан даалтыг ойлгоно гэжээ. Эндээс үзвэл тендерт оролцогчоос банкны батлан даалт шаардсан нь хууль зөрчсөн үйлдэл болжээ.

Хэнтий аймгийн хөтөлбөр хэрэгжүүлэгчээр “Хүнс трейд” ТӨҮГ-ыг шалгаруулсан байна.

“Хүнс трейд” ТӨҮГ нь 2003 онд хувьчлагдаж “Алаг барс” компанид эрхийг нь шилжүүлжээ.

Орхон аймгийн хувьд оролцогч 3 компаний 2 нь нөгөө хоёр аймгийн тендерт шалгарсан, нэгэн зэрэг 2 аймагт хэрэгжүүлэх чадваргүй гэж үзэн “ТБД андууд” ХХК-г шалгаруулсан байна.

Мөн тендерт 300 сая төгрөгөөс дээш дүрмийн сантай, 500 сая төгрөгөөс дээш төгрөгийн үл хөдлөх хөрөнгөтэй аж ахуйн нэгж оролцох болзол тавьсан, банкны батлан даалтыг шалгарсан тохиолдолд шаардах ёстой атал өмнө нь шаардсан зэргээс шалтгаалж орон нутгийн компаниудын оролцох боломжийг хязгаарлаж, оролцсон Улаанбаатар хотын компаниуд шалгарсан байна. Гэтэл тэдгээр нь орон нутагт тэр бүр салбар, бүтэцгүйгээс өөрсдийн салбар нэгжээ байгуулахын тулд хугацаа алдах явдал гарчээ.

2. Санхүү, эдийн засгийн сайд, Үйлдвэр худалдааны сайдын 2003 оны 157/93 дугаар тушаалаар Архангай, Завхан, Өмнөговь, Дорнод аймгуудад “Бөөний худалдааны сүлжээ” шинэчилсэн хөтөлбөрийг хэрэгжүүлэх аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулах тендерийг зохион байгуулахыг СЭЗЯ болон ҮХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга нарт үүрэг болгожээ.

СЭЗЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2003 оны 6 дугаар сарын 3-ны өдрийн 172 дугаар тушаалаар БХС хөтөлбөрийг Архангай, Завхан, Өмнөговь, Дорнод аймгуудад хэрэгжүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах яам дундын тендерийн хороог 9 хүн, үнэлгээний хэсгийг 6 хүний бүрэлдэхүүнтэй баталжээ.

Энэ тендер шалгаруулалтад орон нутгийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжтэй хамтын гэрээ байгуулан оролцох, тендерт шалгарсан нөхцөлд тендерт оролцогч нь тухайн аймагт хуваарилагдсан зээлийн хөрөнгийн 30 хувьтай тэнцэх хэмжээний мөнгийг

Аудитын дүн

хамтран ажиллах аж ахуйн нэгжид олгох зэрэг зарим нэг онцлог болзлыг тусгасан байна.

№	Төсөл хэрэгжүүлэх аймаг	Санал ирүүлсэн аж ахуйн нэгж			
1	Архангай	“Бридж групп” ХХК	“Номин холдинг” ХХК	“Тэнгэр” ХХК	“Таван богд хүнс” ХХК
2	Завхан	“Улаанбаатар импекс” ХХК	“Өлзийт төв” ХХК		“Таван богд хүнс” ХХК
3	Өмнөговь	“Улаанбаатар импекс” ХХК	“Номин холдинг” ХХК	“Тэнгэр” ХХК	
4	Дорнод	“Уолд транс” ХХК	“Талын сувд” ХХК		

Тендерийн нээлтийн ажиллагаанд “Таван богд хүнс” ХХК, “Номин холдинг” ХХК, “Бридж” ХХК гүйцэтгэлийн буюу банкны баталгаа ирүүлээгүй, “Улаанбаатар импекс” ХХК “Талын сувд” ХХК-иуд банкны баталгаа болон хамтран ажиллах орон нутгийн аж ахуйн байгууллагатай гэрээ байгуулаагүй тендерийн бичиг баримтыг ирүүлжээ.

Үнэлгээний хэсэг тендерийн бичиг баримтанд тусгагдсан аргачлалын дагуу төслүүдийг бичиг баримт дээр оноогоор үнэлжээ. Мөн Улаанбаатар болон орон нутаг дахь агуулах, барилга байгууламжтай газар дээр нь очиж танилцан үнэлгээний дүгнэлтийг гаргажээ.

Үнэлгээний үзүүлэлтэд тендерт оролцогчдын бэлтгэсэн төсөлд өгөх үнэлгээ нь нийт үнэлгээний 30 хувийг эзэлж байгаа нь хийгдээгүй ажилд өгч байгаа үнэлгээ бөгөөд үнэлгээний ерөнхий дүн үүнээс голлон шалтгаалж байгаад цаашид анхаарах хэрэгтэй байна.

Жишээ нь: Архангай аймагт төсөл хэрэгжүүлэгчээр саналаа ирүүлсэн 4 компаниас “Номин холдинг” 6 үзүүлэлтээр 68 оноо авсан боловч төслийн үнэлгээ нь бага байснаас хамгийн өндөр оноог авч чадаагүй байна.

Аймгуудад очиж танилцсан тендерийн хорооны гишүүдийн дүгнэлт, төслийн бичиг баримтыг үнэлсэн үнэлгээг үндэслэн тендерийн хорооны 2003 оны 9 дүгээр сарын 13-ны өдрийн хурлын шийдвэрээр Архангай аймагт 83,9 оноогоор “Бридж групп” ХХК, Завхан аймагт 97,0 оноогоор “Өлзийт төв” ХХК, Өмнөговь аймагт 87,7 оноогоор “Номин холдинг” ХХК-иудыг

Аудитын дүн

тус тус шалгаруулсан байна.

БХС
хөтөлбөрийг
хэрэгжүүлэх
зээлийн
гэрээний
биелэлт

Санхүү, эдийн засгийн сайд, Үйлдвэр, худалдааны сайдын 2002 оны 33/10 дугаар тушаалаар Баянхонгор, Хэнтий, Орхон аймгуудад, 2003 оны 157/93 дугаар тушаалаар Завхан, Архангай, Өмнөговь, Дорнод аймгуудад БХС хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр шалгарсан аж ахуйн байгууллагуудтай 3 талын гэрээ байгуулахыг СЭЗЯ-ны болон ҮХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга нарт зөвшөөрчээ.

Үүний дагуу 2002, 2003 онуудад дээрх 7 аймагт шалгарсан аж ахуйн байгууллагууд 3 талын гэрээ (зээлийн гэрээ) байгуулан ажиллаж иржээ.

БХС төслийг хэрэгжүүлэх зээлийн гэрээний 3, 4 дүгээр хэсгүүдэд захиалагч (СЭЗЯ, ҮХЯ), гүйцэтгэгч талуудын эрх, үүрэг, хариуцлагыг зааж өгсөн байна. Үүнд:

1. Захиалагчийн эрх, үүрэг, хариуцлагын талаар

Зээлийн гэрээний 3 дугаар хэсэгт захиалагч тал гэрээнд заасан хэмжээний хөрөнгийг гэрээ байгуулснаас хойш ажлын 5 хоногт багтаан шилжүүлэх, зээлийн хөрөнгийн зориулалт, ашиглалтанд байнгын хяналт тавих, гүйцэтгэгчийн санхүүгийн үйл ажиллагаанд баримтын шалгалт хийх, улирал бүр төслийн үе шатны хэрэгжилтийг газар дээр нь очиж шалгах зэрэг үүргийг хүлээжээ.

БХС төслийн нэгж нь 2002 оны 7 дугаар сард буюу хөтөлбөр батлагдсанаас хойш 8 сарын дараа байгуулагдсан нь хөтөлбөрийн арга хэмжээнүүд хугацаа алдаж хэрэгжихэд нөлөөлжээ.

Тус нэгж нь 2002-2003 онуудад БХС хөтөлбөрийг сурталчлах, судалгаа, сургалт, семинар зохион байгуулах, мэдээлэл цуглуулж сан бүрдүүлэх, вэб сайт нээж ажиллуулах, тайлан мэдээг нэгтгэн холбогдох байгууллагуудад танилцуулах, олон улсын байгууллага, хандивлагч орнуудаас зээл, тусламж олж авах зэрэг ажлуудыг зохион байгуулж иржээ.

Гэвч төслийн нэгжийн үндсэн үүргийн нэг болох тендерт шалгарсан аж ахуйн нэгжийн гэрээгээр хүлээсэн үүргийн хэрэгжилтэд тавих хяналт хангалтгүй явагдаж иржээ. Аудитад хамрагдсан хугацаанд төслийн нэгжээс 2 удаа хөтөлбөрийн хэрэгжилтийг хөтөлбөр хэрэгжиж эхэлсэн эхний 3 аймаг болох

Аудитын дүн

Орхон, Баянхонгор, Хэнтий аймгуудад очиж танилцжээ.

Засгийн газрын 2001 оны 219 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар БХС хөтөлбөрийн ажлыг зохион байгуулах, зохицуулах, хяналт тавих Үндэсний зөвлөлийг Үйлдвэр, худалдааны сайдаар ахлуулан 19 хүний бүрэлдэхүүнтэй байгуулжээ. Мөн Үндэсний зөвлөлийн үйл ажиллагааг дүрмээр зохицуулах, дүрмийг зөвлөл өөрөө батлахаар заажээ.

Гэвч Үндэсний зөвлөлийн үйл ажиллагааг зохицуулах дүрэм батлагдаагүй, 2001-2003 онд Үндэсний зөвлөл 6 гишүүний бүрэлдэхүүнтэй 1 удаа хуралдсан байна.

Хуралдаанаараа БХС хөтөлбөрийн хэрэгжилтийг авч хэлэлцэн хөтөлбөр хэрэгжсэнээр зарим нэг үр дүн гарч байгаа боловч түүхий эд бэлтгэлийн зохистой сүлжээ бий болж чадаагүй, түүхий эд бэлтгэлд биржийн системийг нэвтрүүлэх талаар ахиц гаргаагүй байгааг тэмдэглэн 4 заалт бүхий цаашдын үйл ажиллагаандаа удирдлага болгох удирдамжийг Үндэсний зөвлөлөөс гаргажээ.

Засгийн газрын 2001 оны 219 дүгээр тогтоолд БХС хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг орон нутагтаа зохион байгуулахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасан боловч 2002, 2003 онуудад хөтөлбөр хэрэгжүүлэгч байгууллагуудтай хийсэн гурван талын зээлийн гэрээнд аймгуудын Засаг даргын эрх үүргийг тусгаагүй байна.

2. Гүйцэтгэгчийн эрх, үүрэг, хариуцлагын талаар

Зээлийн гэрээний 4 дүгээр хэсэгт гүйцэтгэгч нь эргэн төлөгдөх нөхцлөөр авсан төсвийн хөрөнгийг зориулалтаар ашиглах, гэрээнд заасан хугацаа, хуваарийн дагуу эргүүлж төлөх, төслийн хэрэгжилтийн талаар дэлгэрэнгүй тайланг улирал тутам гаргаж захиалагчтай тооцоо нийлж байх зэрэг үүрэг хүлээжээ.

Мөн БХС хөтөлбөрийн үндсэн зорилгыг хэрэгжүүлэх үүднээс гүйцэтгэгч дараахь үүргийг хүлээсэн байна. Үүнд:

2.1 Малчид, бэлтгэн нийлүүлэгчдээс түүхий эдийг бэлэн мөнгөөр худалдан авах зарчмыг түлхүү баримтлах бөгөөд түүхий эдийн бэлтгэлд дуудлага худалдааны зарчмыг нэвтрүүлж, бэлтгэх үндсэн нэрийн түүхий эдийн үнийг төсөл хэрэгжсэн эхний жил одоогийн түвшингээс 2-4 хувиар, төсөл хэрэгжиж дуусах 2004

Аудитын дүн

оны эцэст 6-8 хувьд хүргэн нэмэгдүүлэх, зах зээлийн үнэтэй ойртуулах арга хэмжээ авах

Аудитад хамрагдсан 4 аймгаас Орхон аймагт БХС хөтөлбөр хэрэгжүүлж буй “ТБД-Андүүд” ХХК 2002 онд 7067 ширхэг арьсыг дунджаар 12300 төгрөгөөр, 2003 онд 2219 ширхэг арьсыг дунджаар 20000 төгрөгөөр, Архангай аймагт хөтөлбөр хэрэгжүүлж байгаа “Бридж” ХХК 2003 онд өлөн, арьс, ширийг малчдаас 106.0 сая төгрөгөөр худалдан авчээ.

Харин түүхий эдийн бэлтгэлд дуудлага худалдааны зарчмыг нэвтрүүлэх ажил бүх аймагт хийгдээгүй байна.

Түүхий эд бэлтгэлийн үнийн хувьд гэрээнд заасан хувь хэмжээнд хүрч нэмэгдсэн талаар дүгнэлт гаргах бололцоогүй байлаа. Учир нь гэрээнд хөтөлбөр батлагдсан тухайн үед түүхий эдийн үнийн түвшингээс тодорхой хувиар нэмэгдүүлэхээр заажээ. Гэтэл одоо түүхий эдийн үнэ тухайлбал ноолуурын үнэ өмнөх 2 жилийн дунджаас 2 дахин буурсан байгаа. Мөн инфляцийн түвшинг тооцолгүй шууд тодорхой хувиар нэмэгдүүлэхээр заасан нь зах зээлийн зарчимтай зөрчилдөж байгаа юм.

2.2 Бэлтгэсэн түүхий эдийг үндэсний боловсруулах үйлдвэрт нийлүүлэх

Орхон, Баянхонгор аймгуудад хөтөлбөр хэрэгжүүлж байгаа “ТБД-Андүүд” ХХК, “Тэнгэр” ХХК-нууд нь өөрийн болон төслийн хөрөнгөөр мал худалдан авч бэлтгэн мах боловсруулах үйлдвэрт өгч махаа дотоодын хэрэгцээнд нийлүүлж ихэнх хувийг ОХУ-д экспортонд гаргажээ. Малын түүхий эдээ Дархан-Уул аймгийн үйлдвэрүүдтэй гэрээ байгуулан нийлүүлсэн байна. Энэ 2 аймагт мал бэлтгэлийн үеэр улирлын чанартай түүхий эдийн бэлтгэл хийгдэж байна. Аудит хийгдсэн бусад аймагт түүхий эд бэлтгэлийн талаар хийсэн тодорхой ажил байхгүй байна. Аудитаас үзэхэд гэрээний энэ үүрэг бүрэн хэрэгжиж чадахгүй байна.

2.3 Бараа, түүхий эдийн зах зээлийн үнийн мэдээллийг нээлттэй байлгаж, зах зээлийн шударга өрсөлдөөний зарчмыг баримтлан гол нэрийн хүнс өргөн хэрэглээний барааны үнийг тухайн аймагт одоогийн түвшингээс жилд дунджаар 6-8 хувиар бууруулах

Барааны зах зээлийн үнийн мэдээлэл болон гол нэрийн хүнс өргөн хэрэглээний барааны үнэ аудитад хамрагдан хөтөлбөр

Аудитын дүн

хэрэгжиж байгаа аймгуудад зах зээлийн үнэтэй буюу Улаанбаатар хотын захын үнэтэй ойролцоо байгаа нь хийсэн санал асуулгаар харагдлаа.

Гэхдээ аймаг бүрт барааны үнийн түвшин, тухайн орон нутагт БХС хөтөлбөр хэрэгжүүлэгч компаний Бөөний худалдааны төвийн үүрэг роль харилцан адилгүй байна.

Тухайлбал Орхон аймагт ажиллаж байгаа Бөөний худалдааны төв нь гол нэрийн хүнсний бөөний худалдаа эрхэлж байгаа орон нутгийн худалдааны байгууллагуудыг харьцангуй хямд үнэтэй бараагаар хангаж өөрийн тодорхой байр сууриа эзэлж орон нутгийн удирдлага, иргэдээс сайн үнэлэлт авсан байна.

Гэтэл Баянхонгор аймагт ажиллаж байгаа Бөөний худалдааны төв нь гол нэрийн хүнсний бараа худалдаалж байгаа боловч татан авалтыг сард 1-2 удаа хийдгээс үе үе зарим бараа тасрах, ирж байгаа барааны үнэ зарим үед тухайн аймагт худалдагдаж байгаа барааны үнээс өндөр үнээр зарагдаж байгаа нь орон нутгийн удирдлага, иргэдээс авсан санал асуулгаас харагдаж байлаа.

Барааны үнийг бууруулахаар заасан хувь нь инфляци болон зах зээлийн өрсөлдөөн, үнэ ханшны нөлөөллийг тооцоогүй гаргасан тоо тул дүгнэлт өгөх бололцоогүй байлаа.

Тухайлбал 2002 онд 1 кг гурилын үнэ 180-200 төгрөгийн үнэтэй байсан бол инфляци болон нефть бүтээгдэхүүний үнэ, гаднаас импортоор оруулж ирж байгаа гурилын үнэ нэмэгдсэнээр одоо 1 кг гурил 450-600 төгрөгийн үнэтэй байна. Эндээс үзэхэд хөтөлбөрийн үйл ажиллагаанаас шалтгаалахгүй өргөн хэрэглээний хүнсний барааны үнэ өссөн байхад энэ дүнтэй тухайн үеийн үнийн дүнг харьцуулж дүгнэлт хийх боломжгүй байна.

2.4 Түүхий эд бэлтгэл, бөөний худалдааны салбар нэгжийг зээл авсан эхний жил тухайн аймгийн 5 суманд, дараагийн жилд 5 суманд байгуулах бөгөөд төсөл хэрэгжиж дуусахад үлдэх сумуудад байгуулсан байх

Аудитад хамрагдсан 4 аймагт 2003 оны байдлаар Хэнтий аймагт 8, Орхон аймагт 8, Баянхонгор аймагт 6, Архангай аймагт 8 суманд тус тус салбараа нээсэн гэсэн судалгаа гарчээ. Гэвч гэрээний энэ заалт зарим аймгийн засаг захиргааны бүтэцтэй зөрчилдөж байна.

Аудитын дүн

Тухайлбал: Орхон аймаг 3 сумтай. Гэтэл гэрээнд эхний жил 5, дараагийн жил 5 суманд бөөний худалдааны салбар нэгжээ байгуулахаар заасан нь ҮХЯ-ны мэргэжилтэнүүд гэрээний төсөл боловсруулахдаа хянамгай хандаж чадаагүйг харуулж байна. Харин Орхон аймагт БХС хөтөлбөр хэрэгжүүлэгч компани Булган, Хөвсгөл, Сэлэнгэ аймгуудад салбараа нээжээ.

Орхон, Баянхонгор, Хэнтий, Архангай аймгуудын орон нутагт байгуулсан бөөний худалдааны салбар нэгжийн үйл ажиллагаатай танилцахад зөвхөн бөөний худалдааны чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж байгаа нь харагдлаа. Энэ нь хөтөлбөрийн зорилтыг бүрэн хангаж чадахгүй байна.

Мөн аймгуудын сумдад нээсэн бөөний худалдааны салбарын ажиллаж байгаа зарчим харилцан адилгүй байна. Тухайлбал Хэнтий аймагт ажиллаж байгаа салбарууд төв компаниасаа бэлэн мөнгө авч хүнс өргөн хэрэглээний бараагаа өөрсдөө Улаанбаатар хотоос бэлтгэж байхад Баянхонгор аймагт ажиллаж байгаа салбар нь төвөөсөө бараагаа татан авч байгаагаас гадна гэрээ байгуулсан аж ахуйн нэгжид бараагаа бэлэн мөнгөөр олгож байна.

Гэрээнд орон нутагт байгуулсан салбартаа бараагаа хэрхэн яаж өгөх талаар тодорхой заалт алга байна.

Гэвч орон нутагт нээсэн салбарууд нь хүнс өргөн хэрэглээний бараа худалдахаас өөр түүхий эд бэлтгэлийн ямар нэг үйл ажиллагаа хийгээгүй байна.

2.5 Бөөний худалдааны мэдээллийн нэгдсэн сүлжээнд холбогдож бараа, түүхий эдийн хангамж тээвэрлэлтийг оновчтой болгох

Гэрээний үүргийн хувьд тодорхой хийсэн ажил алга байна. Бараагаа зөвхөн Улаанбаатар хотоос авдаг байдал хэвээр байна. Харин Орхон аймагт ашиглалтгүй байсан төмөр замыг ашиглан тээврийн зардлыг хямдруулан бараа татан авалт хийж байгаа нь дэвшилттэй зүйл байна.

2.6 Бусад асуудлын талаар

БХС хөтөлбөр хэрэгжиж байгаа эхний 3 аймагтай хийсэн гэрээнд орон нутгийн хяналтыг орхигдуулсан байна. Мөн тендерт шалгарсан бичиг баримтанд хийхээр төлөвлөсөн ажлуудыг гэрээнд тусгаж өгөөгүй байна. Тухайлбал: Баянхонгор аймагт БХС байгуулах тендерт шалгарсан “Тэнгэр” ХХК тендерийн

Аудитын дүн

бичиг баримтанд 2002 онд Бөөний худалдааны сүлжээний нэгдсэн төв агуулахыг аймгийн төвд байгуулах, 2004 онд Бөөний худалдааны төвд сав баглаа боодлын цех, түүхий эдийн биржийн дэргэд иж бүрэн лаборатори байгуулах санал гэрээнд тусгагдаагүй байна.

Төсвөөс олгосон хөрөнгийн ашиглалт, зарцуулалт, эргэн төлөлт

Санхүү, эдийн засгийн сайд, Үйлдвэр, худалдааны сайдын 2002 оны 33/10 дугаар тушаалаар Баянхонгор, Хэнтий, Орхон аймгуудад БХС хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор 650.0 сая төгрөг, 2003 оны 157/93 дугаар тушаалаар Завхан, Архангай, Өмнөговь, Дорнод аймгуудад БХС хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зориулан 850.0 сая төгрөг, нийт 1500.0 сая төгрөгийн 2,6 жилийн хугацаатай хүүгүй зээл олгохоор зөвшөөрчээ.

2002 онд төслийн нэгж байгуулагдаагүй байсан учраас зээлийг тухайн шалгарсан компаниудад СЭЗЯ-наас шууд олгож, 2003 онд шалгарсан компаниудад төслийн нэгжээр дамжуулан зээлийг хугацаанд нь бүрэн олгосон байна.

Тендерт шалгарсан компаниудын ихэнх нь авсан зээлээ гэрээнд заасан зориулалтын дагуу авч ашигласан байна. Харин Хэнтий аймагт БХС хөтөлбөр хэрэгжүүлэгчээр шалгарсан “Хүнс трейд” компани зээлийг бусдад хүүтэй зээлэхийг санал болгож байсан талаар ҮХ-ны сайдын зөвлөлийн хурлын материалд тэмдэглэсэн байна.

Гэрээнд гүйцэтгэгчийн эргэж төлөгдөх нөхцөлөөр ашигласан төсвийн хөрөнгийг хагас жил тутам 30, 40, 30 гэсэн хувиар төлөхөөр заасан ба хэрэв хугацаандаа төлөөгүй тохиолдолд хугацаа хэтрүүлсэн төлбөрийн дүнгээс хоног дутам 0,3 хувийн алданги төлнө гэж заажээ.

Гэвч зарим компаниуд авсан зээлээ 27-113 хоногоор хоцроож төлсөн байна. Тухайлбал: Төсвийн хөрөнгийн эргэн төлөлтийг 2004 оны 6 дугаар сарын 30-ны байдлаар авч үзэхэд Орхон аймагт БХС төслийг хэрэгжүүлж байгаа “ТБД-Андууд” ХХК 113 хоног хэтрүүлж төлсний алданги 15018.0 мянган төгрөгийг, “Хүнс трейд” ТӨҮГ (Хэнтий аймаг) 27 хоног хэтрүүлсний алданги 4860.0 мянган төгрөгийг, “Тэнгэр” ХХК (Баянхонгор аймагт) 41 хоног хэтрүүлсний алданги 10425.0 мянган төгрөгийг тус тус төлөөгүй байна.

2003 онд ҮХ-ны сайдтай хийсэн ТБ-11 дүгээр гэрээгээр иргэн Л.Чинбат нь Хэнтий аймагт БХС хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр

Аудитын дүн

“Хүнс трейд” ТӨҮГ-ын авсан 180.0 сая төгрөгийн зээлийг төлөх хариуцлагыг хүлээжээ.

Гэрээний дагуу 2003 оны 11 дүгээр сарын 27-нд 121.1 сая төгрөгийг БХС төслийн нэгжийн харилцах дансанд төлбөрийг хийсэн боловч Төслийн нэгжийн зохицуулагч Б.Жадамба улсын төсвийн дансанд оруулалгүй 2004 оны 1 дүгээр сарын 9 хүртэл 44 хоног төслийн дансанд байлгажээ. Үлдэх 58,9 сая төгрөгийг “Алаг барс” ХК-ийн захирал Г.Оюунчимэг төлөхөөр 2004 оны 1 дүгээр сарын 9-нд шилжүүлэн гэрээ хийжээ. Энэ талаар СЭЗЯ-ны Өрийн удирдлагын хэлтсийн холбогдох албан тушаалтнууд мэдээгүй байлаа.

2004 оны 6 дугаар сарын 30-ны байдлаар 188.3 сая төгрөгийн зээл хугацаандаа төлөгдөөгүй байна.

Ийнхүү СЭЗЯ, ҮХЯ үүргээ хангалтгүй биелүүлж байгаагаас зээл авсан компаниудын зээлийн эргэн төлөлт хангалтгүй, хугацаа хэтрүүлж төлөх явдал нийтлэг байна.

“Бөөний худалдааны сүлжээ” төслийн нэгжийн 2002, 2003 оны төсвийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалт

БХС төслийн нэгж нь Үйлдвэр, худалдааны яамны Худалдааны бодлого, хамтын ажиллагааны газрын удирдлага, хяналтын дор үйл ажиллагаагаа явуулдаг ба улсын төсвөөс санхүүжиж иржээ.

БХС төслийн нэгжийн төсвийг 2002 онд Санхүү, эдийн засгийн сайд, Үйлдвэр, худалдааны сайдын 102/44 дүгээр тушаалаар 125.0 сая төгрөг, 2003 онд Үйлдвэр, худалдааны сайдын 39 дүгээр тушаалаар 100.0 сая төгрөгөөр тус тус баталжээ.

Гэвч БХС төслийн нэгжийн төсөвт ажил төрлийн холбоогүй өөр байгууллагын төсөв хамт батлагдан ирдэг байна. Тухайлбал 2003 онд БХС-г гадаадын хөрөнгө оруулалтаар дэмжих, судалгаа сурталчилгааны ажилд 40.0 сая төгрөгийг экспортыг дэмжих үйл ажиллагааны зардалд төсөвлөсөн боловч санхүүжилт нь СЭЗЯ-наас Гадаадын Хөрөнгө Оруулалт Гадаад Худалдааны агентлагийн дэргэдэх Экспортыг дэмжих төвийн дансанд хуваарилагдан олгогджээ.

Экспортыг дэмжих төвийн төсвийн зарцуулалтыг шалгах гэсэн боловч ГХОГХ-ны агентлагийн нягтлан бодогч Б.Болдбаатар ямар ч үндэслэлгүйгээр шалгуулаагүй ба тус төв нь байгуулагдсанаасаа хойш нягтлан бодох бүртгэлийн тайлан баланс гаргаагүй, энэ талаар СЭЗЯ-ны Төрийн сангийн хэлтэс хяналт тавьж ирээгүй байна.

Аудитын дүн

БХС төслийн нэгжийн 2002 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг СЭЗЯ баталгаажуулж хянаагүй байна.

Аудит хийх явцад Үйлдвэр, худалдааны сайдын 2004 оны 52 дугаар тушаалаар 8280 фунт стерлинг буюу 17.3 сая төгрөгийг “Замын-Үүд” эдийн засгийн чөлөөт бүсийг байгуулж хөгжүүлэх, үйл ажиллагааг нь менежментийн гэрээгээр хэрэгжүүлэх стратегийн хөрөнгө оруулагчдыг сонгон шалгаруулах олон улсын нээлттэй тендерийн зар мэдээний төлбөрт шилжүүлж БХС төслийг хэрэгжүүлэх, эрчимжүүлэх арга хэмжээний зардлаас гаргасан байна.

ҮХ-ны сайд БХС төслийн 2003 оны санхүүжилтээс Архангай аймгийн “УУ хөтөл” хоршоо болон “Бум хайрхан” зэрэг компаниудад гэрээ байгуулан 9.8 сая төгрөг олгожээ.

Гэтэл гэрээний хэрэгжилтийн талаар ирүүлсэн ажлын тайлан болон Архангай аймгийн Хайрхан сумын засаг даргын тодорхойлолтоор Архангай аймгийн Хайрхан суманд “Бум хайрхан” ББН ганцаараа БХС хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа ба 2003 оны 4 дүгээр сарын 21-нд 3.0 сая төгрөгийн эргэн төлөлт хийжээ.

Энэ нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журмын тухай” хуулийг зөрчжээ.

Иймд хууль зөрчиж олгосон дээрх 6.8 сая төгрөгийг нөхөн төлүүлэхээр БХС төслийн нэгжийн зохицуулагч Б.Жадамбад хариуцуулан акт тогтоолоо.

Аудитын дүгнэлт

БХС хөтөлбөрийн хэрэгжилтэд хийсэн аудитын дүнг үндэслэн дараахь дүгнэлтийг хийж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2001 оны 219 дүгээр тогтоолоор баталсан БХС хөтөлбөр хэрэгжиж эхэлснээр хөтөлбөрт хамрагдсан 7 аймагт хүнсний болон өргөн хэрэглээний барааны хангамж, чанар сайжирч, үнэ нь Улаанбаатар хотын захын үнэтэй ойролцоо болсон байна.

Аймгуудад хөтөлбөр хэрэгжүүлэгч аж ахуйн байгууллагууд 2002-2003 онуудад 20200 ширхэг арьс шир бэлтгэн үндэсний үйлдвэрлэлд нийлүүлснээс гадна, хөтөлбөрийн хүрээнд мал аж ахуйн гаралтай түүхий эдийн болон өргөн хэрэглээний хүнсний бүтээгдэхүүний 58 стандартыг боловсруулан батлуулжээ.

БХС хөтөлбөрийг хэрэгжүүлэх хөрөнгийн гадаад эх үүсвэрийг бий болгоход санаачлагатай ажиллаж Европын холбооны тусламжийн 1.7 сая еврогоор зүүн 3 аймагт БХС хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн байна.

Мөн БХС хөтөлбөрийг сурталчлах, судалгаа, сургалт, семинар, зохион байгуулах, мэдээлэл цуглуулж сан бүрдүүлэх, вэб сайт нээж ажиллуулах, тайлан мэдээг нэгтгэн холбогдох байгууллагуудад танилцуулах зэрэг ажлыг зохион байгуулсан байна.

Гэвч Засгийн газрын 2001 оны 219 дүгээр тогтоолоор батлагдсан БХС шинэчилсэн хөтөлбөрт заагдсан Худалдааны тухай хууль болон түүхий эдийн агуулахын стандарт боловсруулах, бөөний худалдааны мэдээллийн төв байгуулах, түүхий эдийн төрөлжсөн бирж байгуулах, түүхий эд, барааны дүнгээр вексель, өрийн бичиг гаргах зэрэг зорилтууд биелэгдээгүй байна. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд заасан 9 арга хэмжээнээс 1 арга хэмжээ биелэгдэж, 4 арга хэмжээ дутуу биелэгдэн 4 арга хэмжээ биелэгдээгүй байна.

“Бөөний худалдааны сүлжээ” шинэчилсэн хөтөлбөрийг батлан гаргахдаа бодит байдлын шинжилгээ, судалгаа хийгээгүй, хөтөлбөрийн үр дүнг тооцох тодорхой шалгуур тогтоогоогүй байсан нь аудитын дүгнэлт гаргахад бэрхшээлтэй байлаа.

Аудитын дүгнэлт

Аймгуудад БХС хөтөлбөр хэрэгжүүлэгч аж ахуйн нэгжүүдийг сонгон шалгаруулах тендерийг зохион байгуулахдаа тендерийн үнэлгээний аргачлалыг нарийн тооцож боловсруулаагүй, хөтөлбөрийн зорилтыг шалгуур үзүүлэлтэнд бүрэн оруулаагүй, “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журмын тухай” хуулийг зөрчин тендерийн бичиг баримт дутуу байхад шалгаруулалт явуулсан байна.

Хөтөлбөр хэрэгжүүлж байгаа аймгуудад БХС хөтөлбөрийн хүрээнд зөвхөн бөөний худалдааны үйл ажиллагаа явагдаж, харин түүхий эдийн бэлтгэл, бирж байгуулах асуудал үндсэндээ орхигдсон байна.

Хөтөлбөр хэрэгжүүлэгч зарим компаниуд улсын төсвөөс авсан зээлээ хугацаандаа төлөөгүйгээс хугацаа хэтэрсний алданги 30,3 сая төгрөгийг төлөөгүй бөгөөд 2004 оны 6 дугаар сарын 30-ны байдлаар 188,3 сая төгрөгийн зээл хугацаандаа төлөгдөөгүй байна.

Засгийн газрын 2001 оны 219 дүгээр тогтоолоор “Бөөний худалдааны сүлжээ” шинэчилсэн хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа дуусахад цаашид авах арга хэмжээний талаар гэрээнд тодорхой заалт тусгаагүй байна.

БХС хөтөлбөрийн ажлыг зохион байгуулах, зохицуулах, хяналт тавих үүрэг бүхий Үндэсний зөвлөл нь үйл ажиллагааны дүрмээ батлаагүй, 2001-2003 онд 1 удаа хуралдсан байна. Мөн 3 талын гэрээгээр хүлээсэн хяналт тавих үүргээ ҮХЯ, СЭЗЯ хангалтгүй биелүүлж иржээ.

ҮХ-ны сайд БХС төслийн нэгжийн төсвөөс “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журмын тухай” хуулийг зөрчин 9.8 сая төгрөгийг “Бум хайрхан” ББН-нд, мөн 40.0 сая төгрөгийг БХС төслийн нэгжийн үйл ажиллагаатай холбоогүй Экспортыг дэмжих төвд олгосон байна.

Түүнчлэн “Замын-Үүд” эдийн засгийн чөлөөт бүсийг байгуулж хөгжүүлэх, үйл ажиллагааг нь менежментийн гэрээгээр хэрэгжүүлэх стратегийн хөрөнгө оруулагчдыг сонгон шалгаруулах олон улсын нээлттэй тендерийн зар мэдээний төлбөрт 17.3 сая төгрөгийг батлагдсан төсвөөс гадуур зарцуулсан байна.

Холбогдох байгууллагын санал

Санхүү, эдийн засгийн яамны санал



ҮНДЭСНИЙ АУДИТЫН
ГАЗАРТ

МОНГОЛ УЛСЫН САНХҮҮ ЭДИЙН ЗАСГИЙН ЯАМ

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Нэгдсэн үндэстний гудамж 5/1, Засгийн газрын II байр,
Утас/факс: 32-02-47, E-mail: ulaan@pmls.mof.gov.mn
http://www.mof.gov.mn

2004.07.26 № 5-76/2453
танай _____-ны № _____-т

Санал өгөх тухай


Засгийн газрын 2001 оны 219 дүгээр тогтоолоор батлагдсан "Бөөний худалдааны сүлжээ" хөтөлбөрийн явц, үр дүнг шалгасан гүйцэтгэлийн аудитын тайлантай танилцлаа. Аудитын үйл ажиллагаа нь "Бөөний худалдааны сүлжээ" хөтөлбөрийн хэрэгжилтийн явц байдал, цаашид хэрэгжүүлэх эсэх талаар дүгнэлт гаргахад цаг үеэ олсон, үр дүн сайтай шалгалт боллоо гэж үзэж байна. Гүйцэтгэлийн тайланд дурьдсан дүгнэлттэй санал нэг байгаа ч зайлшгүй анхаарах шаардлагатай зарим асуудал байна.

Бөөний худалдааны сүлжээ хөтөлбөрийг хэрэгжүүлж буй аж ахуйн нэгжүүдийн хугацаа хэтэрч төлөгдсөн зээлийн алдангийг барагдуулах арга хэмжээг авч ажилласанаар 2004 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар "ТБД Андууд" ХХК-ийн хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлд тооцсон 15,018.0 мянган төгрөг, "Тэнгэр" ХХК-д хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлд тооцсон 10,800.00 мянган төгрөгийн төлбөрийг "Бөөний худалдааны сүлжээ төслийг хэрэгжүүлэх зээлийн гэрээ"-ний 3.4, 4.7 дугаар заалт болон баталгаа гаргасан Кредит, Анод банкуудад 2004 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн 5-76/2240, 5-76/2241 тоотуудаар хүргүүлсэн төлбөрийн нэхэмжлэхийн дагуу алдангийн төлбөрт тооцож улсын төсөвт бүрэн төлүүлсэн.

Түүнчлэн "ТБД Андууд" ХХК-ийн хоёрдахь шатны төлбөрийн алдангид 5,520.0 мянган төгрөг, үндсэн төлбөрт 1,462.0 мянган төгрөгийг, "Тэнгэр" ХХК-ийн алдангид 6,522.6 мянган төгрөг, үндсэн төлбөрт 82,677.4 мянган төгрөгийг тус тус төлүүлж, өнөөдрийн байдлаар хугацаа хэтэрч буй нийт 95,860.6 мянган төгрөгийн төлбөрийг энэ сард багтаан улсын төсөвт бүрэн төвлөрүүлэхийг зээлдэгч аж ахуйн нэгжүүдэд даалгаад байна. Иймд 2003, 2004 онуудын хугацаа хэтэрсэн зээлийн дүнд тооцогдсон алдангийн төлбөрийг улсын төсөвт бүрэн төлүүлсэн тул алдангийн төлбөрийг төлүүлэх тухай гүйцэтгэлийн аудитын дүгнэлт, актыг хүлээн зөвшөөрөхгүй байна.

Мөн гадаадын хөрөнгө оруулалт, гадаад худалдааны агентлагийн Экспортыг дэмжих сан нь хуулийн этгээд бус тул санхүүгийн тайлан тэнцэл гаргадаггүй бөгөөд тус агентлагийн санхүүгийн тайланд нэгтгэгддэг, Бөөний худалдааны төслийн нэгжид санхүүжилтийг хуваарийн дагуу олгож гүйцэтгэлийг сар бүр хянаж улсын төсвийн гүйцэтгэлийн мэдээнд нэгтгэгдэж ирүүлсэн тул гүйцэтгэлийн аудитын тайланд тусгагдсан Гадаадын хөрөнгө оруулалт, гадаад худалдааны агентлагийн Экспортыг дэмжих сан болон бөөний худалдааны сүлжээний санхүүгийн тайланг Санхүү, эдийн засгийн яамнаас баталгаажуулж хянаагүй байна гэсэн нь бодит байдалтай нийцэхгүй байгааг анхаарч эргэн нягтлан нь зүйтэй гэж үзэж байна.

Дээр дурьдсан мөхцөл байдлыг аудитын дүгнэлтэнд харгалзан үзэж, тусгахыг хичээнгүйлэн хүсье. Холбогдох санхүүгийн баримтууд, дансны хуулгыг хавсаргаав.



ТӨРИЙН НАРИЙН
Бичгийн дарга

М.Хүрэлбаатар

Ч.ХҮРЭЛБААТАР

08 2099

Тайлбар 1-ийг үзнэ үү.

Тайлбар 2-ыг үзнэ үү.

Холбогдох байгууллагын санал

Үйлдвэр,
худалдааны яамны
санал



МОНГОЛ УЛСЫН ҮЙЛДВЭР ХУДАЛДААНЫ ЯАМ

210648 Улаанбаатар хот,
Чингэлтэй дүүрэг, Нэгдсэн үндэстний гудамж 5/1,
Засгийн газрын II байр, А корпус, Утас: 32-29-81, Факс: 32-25-95
E-mail: mit@mit.pmis.gov.mn, http://www.mit.pmis.gov.mn

2004.9.26 № 1/1460
танай _____ -ны № _____ -т

Гүйцэтгэлийн аудитын тайлангийн
төсөлд өгөх санал

МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ
АУДИТЫН ГАЗРЫН ЕРӨНХИЙ
АУДИТОР Л. ЖАВЗМАА ТАНАА

Монгол Улсын Үндэсний Аудитын газраас "Бөөний худалдааны сүлжээ" хөтөлбөр, түүний хэрэгжилтийн явцын талаар хийсэн аудитын дүгнэлттэй танилцлаа.

Засгийн газраас хэрэгжүүлж буй "Бөөний худалдааны сүлжээ" хөтөлбөрийн хэрэгжилтэнд аудит хийж байгаа нь зүйтэй юм.

Аудитын тайлангаар "Бөөний худалдааны сүлжээ" хөтөлбөрийн хэрэгжилттэй холбоотой баримт бичигтэй танилцах, мөн Орхон аймагт "ТБД-Андууд" ХХК, Хэнтий аймагт "Алагбарс" ХХК, Баянхонгор аймагт "Тэнгэр" ХХК-иудын үйл ажиллагаатай газар дээр нь очиж танилцсан билээ. Аудитын дүгнэлтэд тусгагдсан зарим асуудлаар тус яам доорх саналтай байна. Үүнд:

Тайлбар 3-ыг үзнэ үү.

1. Аудит хийсэн тайлангийн төслийн дүгнэлтэд "Бөөний худалдааны сүлжээ" хөтөлбөрийн явц, үр дүн хангалтгүй байна гэснийг тус яам буруу дүгнэлт гэж үзэж байна. Аудитын шалгалт хийхдээ "Бөөний худалдааны сүлжээ" хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад өнгөрсөн хугацаанд гарсан нааштай өөрчлөлтүүд, бэрхшээл, түүнийг арилгах талаар зохих дүгнэлт өгөхгүйгээр зөвхөн төсвийн зээлийн хөрөнгийн эргэн төлөлтийн явц дээр онцгойлон анхаарч, хэт өрөөсгөл дүгнэлт хийсэн байна. Үйлдвэр, худалдааны яам нь "Бөөний худалдааны сүлжээ" төслийн хэрэгжилтын явцад ба йнгын хяналтыг "Бөөний худалдааны сүлжээ" төсөл хэрэгжиж буй аймгуудын Засаг даргын албатай хамтарч хэрэгжүүлж байна. Тус яам нь "Бөөний худалдааны сүлжээ" хөтөлбөрийн хэрэгжилт, тухайлбал хүнс, өргөн хэрэглээний барааг тасралтгүй нийлүүлэх, түүхий эд бэлтгэх, сумдад бөөний худалдааны салбар, цэгийг байгуулах, зээлийн эргэн төлөлт зэрэг асуудалд иж бүрнээр хяналт тавьж, хэрэгжилтийн явцыг хагас жилд нэг удаа Засгийн газарт, улирал тутам УИХ-ын Эдийн Засгийн Байнгын Хороонд танилцуулж байсан. Төр, засгийн дээд байгууллагууд "Бөөний худалдааны сүлжээ" хөтөлбөрийн хэрэгжилтийг хэлэлцээд нааштай ахиц гарсныг тэмдэглэж цаашид сүлжээг бусад аймгуудад байгуулах ажлыг эрчимжүүлж талаар чиглэл өгч байлаа. Нөгөөтэйгүүр "Бөөний худалдааны сүлжээ" төсөл хэрэгжиж буй аймгуудын удирдлага тус хөтөлбөрийн хэрэгжилтэд талархаж байгаа. 2002 онд Орхон, Хэнтий, Баянхонгор аймгуудад, 2003 онд Завхан, Архангай, Дорнод, Өмнөговь аймгуудад төсөл хэрэгжүүлж байгаа, 2004 онд Ховд, Увс, Говь-Алтай, Хөвсгөл аймгуудад "Бөөний худалдааны сүлжээ" төслийг хэрэгжүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулаад байна. "Бөөний худалдааны сүлжээ" хөтөлбөрийг хэрэгжүүлснээр худалдааны мэрэгжсэн, санхүүгийн чадвартай томоохон компаниудыг хөдөө, орон нутагт чиглүүлсэн үйл ажиллагаа явуулж орон нутагт суурьшин, орон нутгийн аж ахуйн нэгжүүдтэй хамтран ажиллаж байгаа нь тэдний үйл ажиллагааг бэхжүүлэхэд чухал алхам болж байна.

082485

Холбогдох байгууллагын санал


2004 оны эхний улирлын байдлаар Бөөний худалдааны сүлжээ хөтөлбөр хэрэгжүүлэгч компаниуд төсвийн зээл 1500.0 сая төгрөгөөс гадна өөрийн хөрөнгөөс 2116.5 сая төгрөг зарцуулсан. Тухайлбал Баянхонгор аймагт "Тэнгэр" ХХК нь 200 сая төгрөг, Орхон аймагт "ТБД-Андууд" ХХК нь 1916.5 сая төгрөг, Завхан аймагт "Өлзийт төв" ХХК нь 77 сая төгрөг, Архангай аймагт "Бридж" ХХК нь 72.3 сая төгрөгийн хөрөнгийг тус тус оруулаад байна. Үүнээс 1165.5 сая төгрөгийг бараа, үйлчилгээнд, 1389.1 сая төгрөгийг түүхий эд бэлтгэлд, 1186.6 сая төгрөгийг хөрөнгө оруулалтад зарцуулсан байна. Үүний үр дүнд нийт 336 гаруй ажлын байр шинээр бий болж, хүнс, өргөн хэрэглээний барааны үнэ дунджаар 6-8 хувиар буурч, 62 гаруй сумдад бөөний худалдааны салбар ажиллаж байна. Энэ нь хөтөлбөрийн үндсэн зорилт зохих түвшинд хэрэгжиж байгааг харуулж байна.

Тайлбар 4-ыг үзнэ үү.

2. Энэ оны 6-р сарын 30-ны байдлаар Орхон аймагт "ТБД-Андууд" ХХК, Баянхонгор аймагт "Тэнгэр" ХХК-иудад төсөл хэрэгжүүлэхээр олгосон төсвийн зээлээс 188.3 сая төгрөгийг хугацаанд нь эргүүлэн төлөөгүй байсан. Тус яам нь СЭЗЯ-тай хамтран хугацаандаа төлөөгүй зээлийг барагдуулах арга хэмжээ авсны үр дүнд одоогоор төлөөгүй зээл 43 сая төгрөг байна. Дээрх гүйцэтгэгч компаниуд нь зээлийн төлбөрийн үлдэгдлийг алдангийн хамт 10 хоногийн дотор төлөхөөр а мралт ав аад байна. Нөгөөтэйгүүр СЭЗЯ нь "Бөөний худалдааны сүлжээ" төслийг хэрэгжүүлж буй компаниуд хугацаандаа зээлийн төлбөрөө төлөхгүй тохиолдолд "Гүйцэтгэлийн баталгаа гаргасан банкнаас нь зээлийн төлбөрийг ш ууд татахаар гэрээ"-тэй билээ. ҮХЯ-ны "Бөөний худалдааны сүлжээ" төслийн нэгжид гарсан зарим дутагдлыг арилгах, "Бөөний худалдааны сүлжээ" хөтөлбөрийг эрчимжүүлэх талаар үе шаттай арга хэмжээ авч ажиллаж байна.

Тайлбар 5-ыг үзнэ үү.

3. "Бөөний худалдааны сүлжээ" төслийн нэгжийн өөрийн хөрөнгийн зарцуулалтын тухайд гэвэл, тухайлбал Бөөний худалдааны сүлжээ хөтөлбөрийн хэрэгжүүлэх арга хэмжээний төсвийг хэмнэх замаар тус яамны Гадаадын хөрөнгө оруулалтын газарт 40 сая төгрөг, Архангай аймгийн Хайрхан сумын "Бөөний худалдааны сүлжээ" төсөл хэрэгжүүлэхэд зориулан 9,8 сая төгрөг, "Замын-Үүд" чөлөөт бүсийн сурталчилгаанд 17,3 сая төгрөг зарцуулсан байна. "Бөөний худалдааны сүлжээ" хөтөлбөр амжилттай хэрэгжиж байгаа бөгөөд цаашид эрчимжүүлж ажиллах шаардлагатай байна гэсэн Яамны саналыг харгалзан үзэхийг хүсч байна. "Бөөний худалдааны сүлжээ" хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад хийсэн аудитын тайлангийн төсөлд хийсэн зарим дэлгэрэнгүй тайлбарыг "Бөөний худалдааны сүлжээ" төслийн нэгж түүгээрээ хүргүүлсэн болно.



О. ЭРДЭНЭЭ

Холбогдох байгууллагын санал

Үндэсний аудитын газрын тайлбар

Төрийн аудитын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 3-ын 2-т “аудит хийлгэсэн байгууллагаас ирүүлсэн саналыг судлан үндэслэлтэй гэж үзвэл тайланд засвар оруулах, үндэслэлгүй гэж үзвэл өөрийн дүгнэлтийг нэмэлт нотлох зүйлээр бататгах арга хэмжээ авах” гэж заасны дагуу дараахь тайлбарыг өгч байна. Үүнд:

Тайлбар-1 БХС хөтөлбөрийг хэрэгжүүлж буй аж ахуйн нэгжүүдийн төсвийн хөрөнгийн эргэн төлөлтийг 2004 оны 6 дугаар сарын 30-ны өдрөөс хойш авч үзвэл “Тэнгэр” ХХК 100.0 сая төгрөг, “ТБД-Андууд” ХХК 22.0 сая төгрөгийг төсвийн зээлийн үндсэн төлбөрт гэж Санхүү, эдийн засгийн яамны Төрийн сангийн дансанд төлжээ. Энэ нь төсвийн зээлийг хугацаандаа төлөөгүйн алданги биш БХС төслийг хэрэгжүүлэх зээлийн гэрээний дагуу төлөгдөж байгаа төлбөр юм. Мөн ҮАГ-т ирүүлсэн “ТБД-Андууд” ХХК-ны 2004 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн 43 дугаар албан бичигт дээрх 22.0 сая төгрөгийг зээлийн үндсэн төлбөрт төлсөн гэжээ.

СЭЗЯ-ны тайлбарыг үндэслэн төсвийн зээлийг хугацаандаа төлөөгүйн алданги 30.3 сая төгрөгийг СЭЗЯ-нд хариуцуулан акт тавихаа больж, СЭЗЯ барагдуулах арга хэмжээг түүгээрээ авах зөвлөмжийг тайлангийн “Зөвлөмж” хэсэгт тусгав.

Тайлбар-2 БХС төслийн нэгжээс санхүүжигдэж байгаа Экспортыг дэмжих төв нь сан биш бөгөөд түүний санхүүжилтийн зарцуулалт нь Гадаадын хөрөнгө оруулалт, гадаад худалдааны агентлагийн санхүүгийн тайлан тэнцэлд нэгтгэгдэж гардаггүй байна. Иймд энэхүү төвийн санхүүжилт, тайлагналд зохих хяналт тавьж ажиллах зөвлөмжийг Үйлдвэр, худалдааны сайдад хариуцуулан тайлангийн “Зөвлөмж” хэсэгт нэмж тусгав.

Тайлбар-3 ҮХЯ-ны саналын 1 дүгээрт бичсэн тайлбарыг үндэслэн “Хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх шаардлагатай байна” гэсэн аудитын дүгнэлтийг өгөв.

Тайлбар-4 2004 оны 6 дугаар сарын 30-ны байдлаар хугацаандаа төлөгдөөгүй зээлийн үлдэгдэл 188.3 сая төгрөг бөгөөд аудитын үр дүнд ҮХЯ дорвитой арга хэмжээ авч хугацаандаа төлөөгүй зээлийг барагдуулах арга хэмжээ авсан нь сайшаалтай. Гэхдээ энэ нь 2004 оны 7 дугаар сарын 23-ны байдлаар хугацаандаа төлөөгүй зээлийн үлдэгдэл 43.0 сая төгрөг биш 66.3 сая төгрөг бөгөөд үүнээс гадна хугацаа болоогүй зээлийн үлдэгдэл нь 216.8 сая

Холбогдох байгууллагын санал

төгрөг юм.

Тайлбар-5 ҮХЯ-наас ирүүлсэн саналын 3 дугаарт бичсэн тайлбар нь аудитын явцад баримтаар нотлогдсон зөрчлүүдийг хайцаалах гэсэн л оролдлого байна. Энэ талаар аудитын дүнгийн хэсэгт тодорхой дурдсан болно.

Аудитын зөвлөмж

Аудитын дүгнэлтэд үндэслэн дараахь зөвлөмжийг өгч байна.
Үүнд:

НЭГ.Санхүү, эдийн засгийн сайдад:

1.БХС хөтөлбөр хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж байгууллагуудад олгосон зээлээс хугацаандаа төлөгдөөгүй 188,3 сая төгрөгийг барагдуулах арга хэмжээ авах, гэрээгээр хүлээсэн зээлийн хөрөнгийн ашиглалт, зарцуулалтад хяналт тавих үүргээ хэрэгжүүлж ажиллах;

ХОЁР.Үйлдвэр, худалдааны сайдад:

1.БХС хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө хангалтгүй хэрэгжиж байгаад анхаарч эрчимжүүлэх арга хэмжээ авах;

2.Хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж, байгууллагуудтай хийсэн гэрээний биелэлтийг гэрээнд заасан хугацаанд дүгнэж хэрэгжилтэд нь тавих хяналтаа сайжруулах;

3.Засгийн газрын 2001 оны 219 дүгээр тогтоолоор байгуулагдсан Үндэсний зөвлөлийн дүрмийг батлан гаргаж, БХС хөтөлбөрийн үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах;

4.Хөтөлбөр хэрэгжүүлэгч аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулах үнэлгээний аргачлалыг хөтөлбөрийн зорилтуудтай нягт уялдуулан боловсронгуй болгох;

5.Экспортыг дэмжих төвийн үйл ажиллагааны зардлын санхүүжилтийг ГХОГХ-ны агентлагийн төсөвт тусгах, тус төвийн төсвийн зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах;

ГУРАВ. “Бөөний худалдаа сүлжээ” төслийн нэгжид:

1.Засгийн газрын 2001 оны 219 дүгээр тогтоолоор батлагдсан БХС хөтөлбөрийн хэрэгжилтэд тавих хяналтаа сайжруулах, хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийг хангаж ажиллах;

2.БХС төслийн нэгжийн батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын тайлантай холбоотой асуудлаар нэмж тодруулах,
асууж лавлах зүйл байвал 263533 дугаарын утас, 323266
дугаарын факсаар харилцана уу.

Үндэсний аудитын газрын хоёрдугаар
хэлтсийн дарга О.Мэндбаяр